



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/22

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд “Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт орчны шинжилгээ хийлгэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Н.Батцэцэг (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

З.Саранцэцэг (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд:

Н.Намуунцэцэг /зөвшилцсөнөөр/  
(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

2. “Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт орчны шинжилгээ хийлгэх ажил”-ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажлыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг хэсгийн дарга (Н.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ